

Нэр дэвшүүлээ.

Төрийн албаны салбар зөвлөлийн 2015 оны 09 сарын 18 ны өдрийн хуралдаанаар Төрийн байгууллагын төсвийн шууд захирагч, удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцэн Зүүнхангай сумын ИТХ-ын нарийн бичгийн даргаар Эрдэнэцогтын Одгэрэл, Өмнөговь сумын ЭМТ-ийн эрхлэгчээр Чулууны Өргөжих, Улаангом сумын Соёлын төвийн эрхлэгчээр Дүмбээгийн Алтанчимэг, Тэс сумын Соёлын төвийн эрхлэгчээр Батжаргалын Оюунчимэг нарыг тус тус томилуулахаар санал болгон нэр дэвшүүлсэн тогтоолыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүллээ.

Мөн зарим сумын ЗДТГ-аас ирүүлсэн Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоон дээр төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн бүртгэлээс иргэнийг ажиллуулах тухай саналыг хэлэлцээд Баруунтуруун сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны даргаар Батсүхийн Мөнхтогтохыг, Сагил сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны төсөв төрийн сангийн мэргэжилтнээр Мэгзэмийн Минжигмааг, Түргэн сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны төсөв төрийн сангийн мэргэжилтнээр Даваагийн Алимааг, Ховд сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны төсөв төрийн сангийн мэргэжилтнээр Батчулууны Нацагийг томилуулахаар тус тус дүгнэлт гарган нэр дэвшүүллээ.

Нэр дэвшүүлээ.

Төрийн албаны салбар зөвлөлийн 2015 оны 10 сарын 15 ны өдрийн хуралдаанаар Увс аймагт 2015 оны 09 сарын 24 нд зохион байгуулсан Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн шалгалтанд тэнцэж, өрсөлдсөн ажлын байран дээрээ хамгийн өндөр оноо авсан Батбуяны Хүрэлхүүг Баруун туруун сумын газрын даамалаар, Батсүхийн Балжиннямыг Өндөрхангай сумын газрын даамалаар, Жамсрагийн Батцэцэгийг Завхан сумын газрын даамалаар, Далайбаатарын Дэлгэрмөрөнг Увснуурын ай сав газрын УТХГ-ын хамгаалалтын захиргааны Давст, Торхилог хэсгийн байгаль хамгаалагчаар, Буянбатын Нямбарыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Зүүнхангай сумын байгаль хамгаалагчаар, Ганбаатарын Сарантуяаг Өндөрхангай сумын ЗДТГ-ын МЭҮТ-ийн мэргэжилтнээр, Цэрэнчимэдийн Энхтүвшинг Өмнөговь сумын ЗДТГ-ын МЭҮТ-ийн мэргэжилтнээр, Баярсайханы Цэнгэлийг Наранбулаг сумын ЗДТГ-ын байгаль орчны бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтнээр, Сүнрэвийн Батсайханыг Бөхмөрөн сумын, Жамбалын Энхсайханыг Давст сумын, Цэдэвийн Нацагийг Малчин сумын, Санжийн Оюунбилэгийг Наранбулаг сумын, Самбуугийн Лхагвасүрэнг Тэс сумын, Түдэвийн Эрдэнэтуяаг Хяргас сумын Батсайханы Эрдэнэбилэгийг Цагаанхайрхан сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны төсөв төрийн сангийн мэргэжилтнээртус тус томилуулахаар , мөн төрийн жинхэнэ албанд анх орон иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Батаагийн Гантогтохыг Увснуур-Тэс голын сад газрын захиргааны нуурын экосистэмийн үнэлгээ, судалгаа, шинжилгээ хариуцсан мэргэжилтнээр томилуулахаар санал болгон нэр дэвшүүлэв.

Нэр дэвшүүлээ.

Төрийн албаны салбар зөвлөлийн 2015 оны 06 сарын 08 ны өдрийн хуралдаанаар Төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны сул орон тоог нөхөх нөөцийн зараар бүртгүүлсэн иргэдээс Улсын бүртгэлийн хэлтсийн Наранбулаг сумын улсын бүртгэгчээр Ц.Баттулгыг, Татварын хэлтсийн Малчин сумын татварын байцаагчаар Ж.Энхзаяаг, Наранбулаг сумын ЗДТГ-ын иргэний танхим , нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнээр Ю. Сэржмядагийг, Зүүнхангай сумын ЗДТГ-ын иргэний танхим , нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнээр Ц.Эрдэнэзулыг, Түргэн сумын ЗДТГ-ын иргэний танхим, нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнээр Э.Цэнд-Аюушийг, Цагаанхайрхан сумын ЗДТГ-ын иргэний танхим , нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнээр Т.Батсайханыг томилуулахаар тус тус санал болгож нэр дэвшүүлэв.

Увс аймагт 2015 оны 05 сарын 07 нд зохион байгуулсан Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн шалгалтанд тэнцэж, өрсөлдсөн ажлын байран дээрээ хамгийн өндөр оноо авсан Ц.Эрдэнэбаатарыг Боловсрол, соёлын газрын хяналт, үнэлгээ хариуцсан мэргэжилтнээр Ө.Цэдэн-Ишийг МХГ-ын автозамын хяналтын улсын байцаагчаар, Б.Одвогмэдийг ЭМГ-ын амьдралын буруу хэвшлээс хамааралтай өвчний болон настны асуудал хариуцсан мэргэжилтнээр, Д.Өлзийхишигийг Тэс сумын ЗДТГ-ын МЭҮТ-ийн бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтнээр, Ц. Жансамбууг Тариалан сумын МЭҮТ-ийн бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтнээр, Д.Бямбасүрэнг Тэс сумын ЗДТГ-ын байгаль

хамгаалагчаар, С.Дагвасүрэнг Тэс сумын ЗДТГ-ын байгаль орчны бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтнээр , Д.Намсайг Улаангом сумын ЗДТГ-ын барилга байгууламж, худалдаа, эрчим хүч, СӨХ-ийн асуудал хариуцсан мэргэжилтнээр томилуулахаар тус тус санал болгож нэр дэвшүүлэв.